

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ТӨХХК-ИЙН оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/49/НА-СТА-ТӨА

|  |   |
|--|---|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: П.Чанцалдулам<br>Утас: 51-261740 Цахим хаяг: <a href="mailto:chantsaldulamp@audit.gov.mn">chantsaldulamp@audit.gov.mn</a><br>Ахлах аудитор: Э.Энхбаатар<br>Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatare@audit.gov.mn">enkhbaatare@audit.gov.mn</a><br>Аудитор: Д.Шийрэв Шонхор үнэлгээ аудит ХХК<br>Утас: 70150001 Цахим хаяг: <a href="mailto:rusbd.audit@gmail.com">rusbd.audit@gmail.com</a> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/838

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК-ийн харилцагчдын өмчилж буй үнэт цаас нь СТОУС-7 "Санхүүгийн хэрэглүүр": тодруулга, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан 2015 оны 315/А-169/309 дүгээр тушаалаар батлагдсан "Кастодианы санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар"-ын дагуу тэнцлийн гадуур бүртгэгдсэн бөгөөд энэхүү тайланд тусгагдаагүй болно.

### Аудитын гол асуудал

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК -д 2023 оны эцсээр 353 хувьцаат компанийн 99,089.7 сая ширхэг компанийн хувьцаа, 4 хамтын хөрөнгө оруулалтын сангийн 1,302.9 ширхэг нэгж эрх, 401 төрлийн 21,506.6 сая ширхэг Засгийн газрын болон компанийн гаргасан бонд, нийт 758 төрлийн 121,899.3 сая ширхэг үнэт цаас хадгалагдаж байна.

Тайлант онд нийт 35 хувьцаат компанитай ногдол ашгийн гэрээ байгуулж, 165.8 мянган хувьцаа эзэмшигчдийн 1,833.4 сая ширхэг хувьцаанд ногдох 36,436.4 сая төгрөгийн ногдол ашгийг тараасан байна.

Z:\Yawsan\_Bichig\2024\0325 SNAG-46.Docx

0001051931

### **Бусад асуудлын хэсэг**

Компанийн 5 зорилт, 28 чиглэлийн хүрээнд тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 38 ажлыг хэрэгжүүлж, гүйцэтгэх захирлын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар 79.6 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хуралд танилцуулахаар бэлтгэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                            | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|-------------------------------------|------------------------|------------------------|
| <b>1</b>      | <b>ХӨРӨНГӨ</b>                      |                        |                        |
| 1.1           | Эргэлтийн хөрөнгө                   |                        |                        |
| 1.1.1         | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө   | 112,140,264,510.01     | 68,711,770,831.04      |
| 1.1.2         | Дансны авлага                       | 19,482,814.84          | 186,589,478.48         |
| 1.1.3         | Татвар, НДШ-ийн авлага              | -                      | 16,703,892.87          |
| 1.1.4         | Бусад авлага                        | 593,327,541.74         | 1,197,853,034.88       |
| 1.1.5         | Бусад санхүүгийн хөрөнгө            | 15,350,000,015.25      | 24,471,178,782.60      |
| 1.1.6         | Бараа материал                      | 57,041,400.00          | 15,344,862.00          |
| 1.1.7         | Урьдчилж төлсөн зардал /тооцоо      | 37,398,557.65          | 37,203,567.65          |
| 1.1.11        | Эргэлтийн хөрөнгийн дүн             | 128,197,514,839.49     | 94,636,644,449.52      |
| 1.2           | Эргэлтийн бус хөрөнгө               |                        |                        |
| 1.2.1         | Үндсэн хөрөнгө                      | 1,358,764,171.96       | 1,494,411,313.62       |
| 1.2.2         | Биет бус хөрөнгө                    | 55,543,193.15          | 101,006,339.92         |
| 1.2.10        | Эргэлтийн бус хөрөнгийн дүн         | 1,414,307,365.11       | 1,595,417,653.54       |
| 1.3           | Нийт хөрөнгийн дүн                  | 129,611,822,204.60     | 96,232,062,103.06      |
| <b>2</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>      |                        |                        |
| 2.1           | Өр төлбөр                           |                        |                        |
| 2.1.1         | Богино хугацаат өр төлбөр           |                        |                        |
| 2.1.1.1       | Дансны өр төлбөр                    | 41,996,757.01          | 12,149,187.05          |
| 2.1.1.2       | Цалингийн өр төлбөр                 | 3,890,373.99           | 225,521.82             |
| 2.1.1.3       | Татварын өр төлбөр                  | 125,687,725.72         | 39,163.96              |
| 2.1.1.4       | НДШ-ийн өр төлбөр                   | 9,434,987.17           | 2,445,147.55           |
| 2.1.1.8       | Урьдчилж орсон орлого               | 15,442,793.36          | 40,158,007.87          |
| 2.1.1.10      | Бусад богино хугацаат өр төлбөр     | 116,579,973,756.15     | 80,456,653,072.67      |
| 2.1.1.13      | Богино хугацаат өр төлбөрийн дүн    | 116,776,426,393.40     | 80,511,670,100.92      |
| 2.1.2         | Урт хугацаат өр төлбөр              |                        |                        |
| 2.1.2.2       | Нөөц /өр төлбөр/                    | 439,899,200.00         | 526,723,301.65         |
| 2.1.2.6       | Урт хугацаат өр төлбөрийн дүн       | 439,899,200.00         | 526,723,301.65         |
| 2.2           | Өр төлбөрийн нийт дүн               | 117,216,325,593.40     | 81,038,393,402.57      |
| 2.3           | Эздийн өмч                          |                        |                        |
| 2.3.1.1       | - төрийн                            | 5,000,000,000.00       | 5,000,000,000.00       |
| 2.3.4         | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 159,548,938.00         | 159,548,938.00         |
| 2.3.7         | Хуримтлагдсан ашиг (алдагдал)       | 7,235,947,673.20       | 10,034,119,762.49      |
| 2.3.9         | Эздийн өмчийн дүн                   | 12,395,496,611.20      | 15,193,668,700.49      |
| 2.4           | Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн | 129,611,822,204.60     | 96,232,062,103.06      |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                                    | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|---|------------------------|------------------------|
| 1             | Борлуулалтын орлого (цэвэр)                 | 2,208,886,210.28       | 3,871,994,546.05       |
| 2             | Борлуулалтын өртөг                          | 513,847,652.84         | 779,120,273.33         |
| 3             | Нийт ашиг                                   | 1,695,038,557.44       | 3,092,874,272.72       |
| 4             | Түрээсийн орлого                            |                        |                        |
| 5             | Хүүгийн орлого                              | 1,269,703,880.91       | 2,755,953,837.93       |
| 8             | Бусад орлого                                | 69,258.00              | 29,418,146.01          |
| 10            | Ерөнхий ба удирдлагын зардал                | 1,018,677,509.29       | 1,578,397,899.39       |
| 12            | Бусад зардал                                | 16,680,000.00          | 34,434,430.00          |
| 13            | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)  | 539,046.52             | (164,292.38)           |
| 18            | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)       | 1,929,993,233.58       | 4,265,249,634.89       |
| 19            | Орлогын татварын зардал                     | 193,511,200.57         | 512,012,443.95         |
| 20            | Татварын дараах ашиг (алдагдал)             | 1,736,482,033.01       | 3,753,237,190.94       |
| 22            | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)         | 1,736,482,033.01       | 3,753,237,190.94       |
| 23            | Бусад дэлгэрэнгүй орлого                    |                        |                        |
| 24            | Орлогын нийт дүн                            | 1,736,482,033.01       | 3,753,237,190.94       |
| 25            | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) |                        |                        |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт  | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|---|------------------------|------------------------|
| <b>1</b>      | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ                   |                        |                        |
| 1.1           | Мөнгөн орлогын дүн (+)                                  | 1,892,277,921,367.85   | 4,288,764,429,239.95   |
| 1.1.1         | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого            | 2,203,099,876.91       | 3,667,978,527.85       |
| 1.1.6         | Бусад мөнгөн орлого                                     | 1,890,074,821,490.94   | 4,285,096,450,712.10   |
| 1.2           | Мөнгөн зарлагын дүн (-)                                 | 1,821,952,588,459.98   | 4,312,669,789,714.49   |
| 1.2.1         | Ажиллагчдад төлсөн                                      | 758,985,598.52         | 1,113,284,752.57       |
| 1.2.2         | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                  | 200,157,633.84         | 309,313,710.10         |
| 1.2.3         | Бараа материал худалдан авахад төлсөн                   | 80,468,304.00          | 24,252,874.00          |
| 1.2.4         | Ашиглалтын зардалд төлсөн                               | 165,063,729.31         | 58,539,242.53          |
| 1.2.5         | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн   | 1,550,000.00           | 2,311,397.00           |
| 1.2.6         | Хүүгийн төлбөрт төлсөн                                  |                        |                        |
| 1.2.7         | Татварын байгууллагад төлсөн                            | 262,798,740.57         | 790,189,918.22         |
| 1.2.8         | Даатгалын төлбөрт төлсөн                                | 5,294,420.00           | 3,742,010.00           |
| 1.2.9         | Бусад мөнгөн зарлага                                    | 1,820,478,270,033.74   | 4,310,368,155,810.07   |
| 1.3           | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ             | 70,325,332,907.87      | (23,905,360,474.54)    |
| <b>2</b>      | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ       |                        |                        |
| 2.1           | Мөнгөн орлогын дүн (+)                                  | 16,094,875,792.33      | 2,289,031,348.87       |
| 2.1.3         | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого                      | 14,850,000,000.00      |                        |
| 2.1.6         | Хүлээн авсан хүүгийн орлого                             | 1,244,875,792.33       | 2,289,031,348.87       |
| 2.2           | Мөнгөн зарлагын дүн (-)                                 | 20,010,111,803.00      | 20,943,759,260.92      |
| 2.2.1         | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                     | 60,111,803.00          | 380,093,900.00         |
| 2.2.3         | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн                   | 19,950,000,000.00      | 20,504,342,734.92      |
| 2.2.2         | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                   |                        | 59,322,626.00          |
| 2.3           | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (3,915,236,010.67)     | (18,654,727,912.05)    |
| <b>3</b>      | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ               |                        |                        |
| 3.2           | Мөнгөн зарлагын дүн (-)                                 | 719,150,000.00         | 868,241,000.00         |
| 3.2.4         | Төлсөн ногдол ашиг                                      | 719,150,000.00         | 868,241,000.00         |
| 3.3           | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ         | (719,150,000.00)       | (868,241,000.00)       |
| 3.4           | Валютын ханшийн зөрүү                                   | 539,046.52             | (164,292.38)           |
| <b>4</b>      | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                                | 65,691,485,943.72      | (43,428,493,678.97)    |
| <b>5</b>      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл        | 46,448,778,566.29      | 112,140,264,510.01     |
| <b>6</b>      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл       | 112,140,264,510.01     | 68,711,770,831.04      |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт                            | Өмч              | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт дүн          |
|---------------|-------------------------------------|------------------|-------------------------------------|-------------------------------|-------------------|
| 1             | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 5,000,000,000.00 | 159,548,938.00                      | 7,235,947,673.20              | 12,395,496,611.20 |
| 2             | Залруулсан үлдэгдэл                 | 5,000,000,000.00 | 159,548,938.00                      | 7,235,947,673.20              | 12,395,496,611.20 |
| 3             | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 5,000,000,000.00 | 159,548,938.00                      | 7,235,947,673.20              | 12,395,496,611.20 |
| 3             | Залруулсан үлдэгдэл                 | 5,000,000,000.00 | 159,548,938.00                      | 7,235,947,673.20              | 12,395,496,611.20 |
| 4             | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) |                  |                                     | 3,753,237,190.94              | 3,753,237,190.94  |
| 5             | Зарласан ногдол ашиг                |                  |                                     | 955,065,101.65                | 955,065,101.65    |
| 6             | 2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл  | 5,000,000,000.00 | 159,548,938.00                      | 10,034,119,762.49             | 15,193,668,700.49 |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

| д/д | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт                | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Хувь  |
|-----|--|------------------|------------------|-------|
| 1   | Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого | 1,048,828,474.82 | 1,326,013,345.31 | 126.0 |
| 2   | Үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн орлого     | 926,430,911.00   | 1,579,513,354.09 | 170.0 |
| 3   | Кастодианы үйлчилгээний орлого               | 15,996,080.11    | 13,532,916.25    | 85.0  |
| 4   | Төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааны орлого      | 611,912,500.00   | 888,101,278.76   | 145.0 |
| 5   | Бусад орлогын дүн                            | 51,000,000.00    | 94,251,797.65    | 185.0 |
| 6   | Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн           | 2,654,167,965.93 | 3,901,412,692.06 | 147.0 |
| 7   | Үйл ажиллагааны бус орлого                   | 1,776,983,561.64 | 2,755,953,837.93 | 155.0 |
| 8   | Нийт орлого                                  | 4,431,151,527.57 | 6,657,366,529.99 | 150.0 |
| 9   | Нийт зардал                                  | 2,207,433,315.00 | 2,392,116,895.10 | 108.0 |
| 10  | Татварын өмнөх ашиг /алдагдал/               | 2,223,718,212.57 | 4,265,249,634.89 | 192.0 |
| 11  | Татварын зардал                              | 222,371,821.26   | 512,012,443.95   | 230.0 |
| 12  | Цэвэр ашиг /алдагдал/                        | 2,001,346,391.32 | 3,753,237,190.94 | 188.0 |
| 13  | Төрийн өмчийн ногдол ашиг                    | 868,241,000.00   | 868,241,000.00   | 100.0 |
| 14  | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал         | 0.50             | 0.36             | 72.0  |
| 11  | Худалдан авалт                               | 290,870,000.00   | 256,897,985.00   | 88.0  |
| 15  | Нийт ажиллагсдын тоо                         | 40               | 37               | 93.0  |
| 16  | Нийт цалингийн сан                           | 1,417,763,000.00 | 1,296,180,238.05 | 91.0  |

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 6.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |         | Үүнээс        |     |                 |         |         |     |                                      |                     |   |     |
|--|-------------|---------|---------------|-----|-----------------|---------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|  |             |         | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |         | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн     | Тоо           | Дүн | Тоо             | Дүн     | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Санхүүгийн тайланд тайлагнагдсан нэр бүхий 2 компанид төлөх нийт 6.2 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1           | 6,170.6 |               |     | 1               | 6,170.6 |         |     |                                      |                     |   |     |
| Дүн  | 1           | 6,170.6 |               |     | 1               | 6,170.6 |         |     |                                      |                     |   |     |

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 35.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                 | Үүнээс        |     |                 |                 |         |     |                                      |                     |   |     |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
|  |             |                 | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                 | Зөвлөмж |     | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|  | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн | Тоо             | Дүн             | Тоо     | Дүн | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн |
| Шүүхийн шийдвэрээр компанийн хөрөнгөөс нөхөн олговор олгосон дараах асуудлууд байна. Үүнд:<br>-Өмнөх онд шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олговорт олгосон 25.7 сая төгрөгийг буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлж, компанийг хохиролгүй болгох талаар өгсөн ҮАГ-ын 2023 оны №801/А0150061 дүгээр албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;<br>-Тайлант онд Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 182/ШШ2022/03412 дугаар шийдвэрийн дагуу 1 ажилтанд ажиллаагүй хугацааны цалин хөлсний нөхөн олговорт 9.3 сая төгрөгийг олгож, авлагаар бүртгэсэн. | 1           | 34,991.7        |               |     | 1               | 34,991.7        |         |     |                                      |                     |   |     |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>34,991.7</b> |               |     | <b>1</b>        | <b>34,991.7</b> |         |     |                                      |                     |   |     |